



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2022 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Монголын Төв Намыг улсын бүртгэлд
бүртгүүлэх хүсэлтийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн, шүүгч Г.Алтанчимэг, Ч.Хосбаяр, Ч.Тунгалаг, шүүгч Б.Амарбаясгалан, С.Батдэлгэр, Г.Банзрагч, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, П.Золзаяа, Б.Мөнхтуяа, Д.Мөнхтуяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар, Монголын Төв Намын дарга А.Эрдэнэбаярын “Монголын Төв Намыг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай” хүсэлтийг Захиргааны хэргийн танхимын тэргүүн Ч.Тунгалагийн илтгэснээр хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Монголын Төв Намын дарга А.Эрдэнэбаяраас 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Улсын дээд шүүхэд “Монголын Төв Нам үүсгэн байгуулагдсаныг улсын бүртгэлд бүртгүүлэх”-ээр ирүүлсэн хүсэлтдээ:

“Бидний хэсэг, судлаач, эрдэмтэд, залуу үеийн төлөөлөл цахим орчинд өөрсдийн орон зайг үүсгэн, харилцан санал солилцох журмаар бие биетэйгээ танилцаж, үзэл бодол, идэвх санаачилгаараа нэгдэн хамтарч, уулзаж хэлэлцүүлэг өрнүүлж санал бодлоо солилцож, улмаар төв үзэлтэй, олон талт үндэслэл бүхий шинжлэх ухаанч хандлагатай, гишүүн, дэмжигчдийн сайн дураараа эвлэлдэн нэгдсэн улс төрийн нам байгуулах нь зүйтэй гэж үзсэн.

Тиймээс бид эвлэлдэн нэгдэж, “Монголын Төв Нам”-ыг үүсгэн байгуулах Их хурлаа Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, 11 дүгээр зүйлийн 11.2, 12, 13 дугаар зүйлд заасан шаардлага болон Улсын дээд шүүхийн 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 09-р тогтоолд заасан шаардлагуудыг бүрэн ханган зохион байгуулж, холбогдох баримтуудыг бүрдүүлэн хүргүүлж байна.

Иймд бидний хүсэл зорилгыг хүндэтгэн үзэж, Монголын Төв Намыг бүртгэж өгнө үү” гэжээ.

Уг хүсэлтэд, Монголын төв нам үүсгэн байгуулсныг улсын бүртгэлд бүртгүүлэх намын даргын гарын үсэг бүхий өргөдөл /Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын №1/, хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын хуудас, А.Эрдэнэбаярын иргэний үнэмлэхийн хуулбар, “Өглөөний сонин” сонины /2021.09.08. 158 (3463)/ 7 дугаар нүүр, www.tuvnam.mn Монголын төв нам пейж

хуудас дахь “мэдэгдэл” 2 хуудас, 2021 оны 9 дүгээр сарын 07-ны өдрөөр огноолсон “Монголын төв намыг үүсгэн байгуулах “Их Хуралд” оролцох 229 төлөөлөгчдийн нэрсийн жагсаалт, 2021 оны 10 дугаар сарын 21, 22-ны өдрийн огноотой “Их Хуралд” оролцох төлөөлөгчдөд хурлын тов мэдэгдсэн баримт /овог нэр, утас, хаанаас оролцох, тайлбар гэсэн хүснэгттэй/, 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн ТА-21/38 МҮЭ-ийн Соёлын төв ордонд зохиогдох тоглолт, арга хэмжээ, бусад ажил үйлчилгээний гэрээ, 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн төлбөрийн нэхэмжлэх, МҮЭ-ий Соёлын төв ордны захирлын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 118 дугаартай албан бичгээр Улсын дээд шүүхэд гаргасан тодорхойлолт, “Их Хуралд” хүрэлцэн ирсэн намын төлөөлөгчдөд мандат олгосон бүртгэл /103 хүний овог нэр, регистрийн дугаар, оршин суух хаяг, гарын үсэг бүхий/, “Их Хуралд” цахимаар оролцсон намын төлөөлөгчдийн бүртгэл /овог, нэр, регистрийн дугаар бүхий/, Монголын төв намыг үүсгэн байгуулах 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хурлын тэмдэглэл, хурлын тогтоолууд, тооллогын комиссын тогтоолууд, намын бэлгэдэл, далбааны зураг, тайлбарын хамт, намын дүрэм, мөрийн хөтөлбөр, намын гүйцэтгэх байгууллагын хаягийн талаарх тодорхойлолт, намын 960 гишүүний бүртгэл, намын санхүүгийн асуудал эрхэлсэн ажилтны анкет, намын хөрөнгийн мэдээлэл, улсын тэмдэгтийн хураамж 150000 төгрөг төлсөн төлбөрийн баримт, анхдугаар их хурлын төлөөлөгчдийн анкет, хурлын зар түгээх ажиллагаа, хуралдааны болон хурлын төлөөлөгчдийн фото зураг зэрэг 2 хавтас 515 хуудас материалыг хавсарган ирүүлсэн байна.

Хүсэлт болон түүнд хавсаргаж ирүүлсэн баримтууд, гишүүдийн бүртгэлийг нягтлан үзэж тогтоогдсон нөхцөл байдал, сонсох ажиллагаанд хүсэлт гаргагчаас өгсөн тайлбар зэргийг судлан хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь:

1. Хүсэлтэд хавсаргаж ирүүлсэн “Монголын Төв Намын 960 гишүүний бүртгэл”-ийг Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангийн мэдээлэлд нийцүүлэн хянахад регистрийн дугаар буруу 221, эцэг /эх/-ийн нэр болон өөрийн нэр буруу буюу зөрсөн 12, ургийн овог, хаяг дутуу буюу зөрсөн 388, мэдээллийн санд тодорхой хаяггүй 1, регистр өөр 1, регистр бичээгүй 3, 18 нас хүрээгүй, хаяг зөрүүтэй 1, иргэний мэдээлэл бөглөөгүй 3, жагсаалтад бичигдсэн мэдээлэл уншигдах боломжгүй 1 нийт 631 иргэний мэдээллийг дутуу болон зөрүүтэй бүрдүүлж ирүүлсэн нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 10/931 дугаартай албан бичиг, түүний хавсралтаар тогтоогдлоо.

Үүний зэрэгцээ, намд гишүүнээр бүртгүүлсэн нэр бүхий 960 гишүүний жагсаалтаас тохиолдлын журмаар 100 гишүүнээс намын гишүүнчлэлийн талаар утсаар холбогдож асуухад тус намын талаар мэдэхгүй, одоо сонсож байна гэж 18, гишүүний бүртгэлд гарын үсэг зураагүй гэж 6, өөр намын гишүүн гэж 1, холбоо барих тухайн утсыг жагсаалтад нэр нь байгаа хүн эзэмшдэггүй гэж 7 хүн тус тус хариулсан байна.

Иймд, шинээр үүсгэн байгуулсан Монголын Төв Намыг Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.7-д заасан “нам 801-ээс доошгүй гишүүнтэй байх” хуулийн шаардлагыг хангасан гэж үзэх боломжгүй тул мөн хуулийн 10 дугаар

зүйлийн 10.1-д “Улсын дээд шүүх намыг дараахь үндэслэлээр улсын бүртгэлд бүртгэхээс татгалзана: ...10.1.3. гишүүдийн тоо нь энэ хуулийн 9.3.7-д заасан тоонд хүрээгүй буюу бүртгэлд орсон гишүүн нь өөр намын харьяалалтай, эсхүл өөр хүн төлөөлсөн” гэж заасны дагуу бүртгэхээс татгалзах нь зүйтэй гэж Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас дүгнэлээ.

Нам дахин хүсэлт гаргасан тохиолдолд гишүүдийн бүртгэл нь Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-т заасан шаардлага болох “гишүүн өөр намын харьяалалгүй болох талаар” холбогдох баримтыг бүрдүүлж ирүүлэх шаардлагатай.

Дээрх байдлаар улс төрийн нам үүсгэн байгуулахад тавигдах шаардлага буюу гишүүдийн тоо 801-ээс доошгүй байх хуулийн шаардлага хангагдаагүй байх тул Монголын Төв Намыг үүсгэн байгуулсантай холбоотой бусад баримтууд нь Улс төрийн намын тухай хуульд нийцэж байгаа эсэхэд дүгнэлт хийх боломжгүйг тэмдэглэв.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.1.3-т заасныг баримтлан Монголын Төв Намыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсугай.
2. Хүсэлт гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150 000 /нэг зуун тавин мянга/ төгрөгийг төрийн сангийн төсвийн орлогод хэвээр үлдээсүгэй.
3. Энэ тогтоолд гомдол гаргах эрхгүйг дурдсугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ, ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН ТАНХИМЫН
ТЭРГҮҮН, ШҮҮГЧ

Ч.ТУНГАЛАГ